

2013 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банкны холбогдох этгээд болох Си Эн Би Консалтинг ХХК-д Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан “Кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний нөхцөлийн дагуу үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Худалдаа, хөгжлийн банкныг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА